



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1271

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас  
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай" 117 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, нийт 64,994,142.30 (жаран дөрвөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга нэг зуун дөчин хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 51,345,372.48 (тавин нэгэн сая гурван зуун дөчин таван мянга гурван зуун далан хоёр төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий барилга, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн балансад бүртгэлтэй, нийт 44,829,054.00 (дөчин дөрвөн сая найман зуун хорин есөн мянга тавин дөрвөн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй хавсралтад заасан барилгыг тус тус акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төв (З.Сарантуяа)-д, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төв (Ш.Саруултуяа)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 4,524,500.00 (дөрвөн сая таван зуун хорин дөрвөн мянга таван зуун) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төв (З.Сарантуяа)-д, 2,208,371.33 (хоёр сая хоёр зуун найман мянга гурван зуун далан нэгэн төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийг төвлөрүүлэхийг Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төв (Ш.Саруултуяа)-д, орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



1110205627



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	2001	Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо /ханын материалын эцэс/	64,994,142.30	13,648,769.82	51,345,372.48	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагчийн 2024 оны 02-13-01/027/63 дугаар дүгнэлт
2	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн барилга	1962	Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо /Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Москва 41-1 тоот/	44,829,054.00	44,829,054.00	0	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2010 оны 07-276/141 дүгээр дүгнэлт
Нийт дүн				109,823,196.30	58,477,823.82	51,345,372.48	